

2010он Зүүн хойт Азийн засагийн газарын хобоот орчин ахуйн

салбар зөвлөлийн илтгэл материал

I	Хэсэг бүс нутагийн байгаль орчны өнөөгийн байдал ба цаашдын арга хэмжээний тухай илтгэл	1
1	Тояма муж	1
2	Хүкүи муж	3
3	Kyungsangnamdo	4
4	Сахалин муж	9
II	Байгаль орчны эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны байдал	11
1	9 дэх удаагийн байгаль орчны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	11
2	Тусгай хөтөлбөртэй холбогдох судалгааны хэрэгжилт	12
III	Тусгай хөтөлбөр	13
1	2010 оны тусгай хөтөлбөр	13
(1)	Санал болгох төсөл	13
(2)	Зарим нэг бүсийн засаг захиргааны оролцоо	13
(3)	Төслийг хэрэгжүүлэх нөхцөл байдал	15
①	Төсөл No.1	
	5 дахь удаагийн олон улсын байгальорчны форум-хил хязгаараар зааглагдахгүй байгаль (Далайн эргийн бүс)	15
②	Төсөл No.2	
	Шар элсийг зорилгоо болгосон өргөнхүрээний мониторингийн системийг бий болгох (Тояма муж)	18
③	Төсөл No.3	
	Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчны хөтөлбөр (Тояма муж)	20
④	Төсөл No.4	
	Япон тэнгис · Шар тэнгисийн эрэг орчмын далайн давалгаанаасирсэн хаягдал зүйлсийг тухай судалгаа (Тояма муж)	21
2	2011оны тусгай төсөл	23
(1)	Санал болгох төсөл	23
(2)	Зарим бүсийн оролцох хүсэлт гаргасан судалгааны дүн	23

(3) Төслийн байдал	25
① Төсөл No. 1	
Шар элсийг зорилгоо болгосон өргөнхүрээний мониторингийн системийг бий болгох (Тояма муж)	25
② Төсөл No. 2	
Зүүн Хойд Азийн байгаль орчны хөтөлбөр (Тояма муж)	27
③ Төсөл No. 3	
Далайн эргийн хаягдлын судалгааны ажил (Тояма муж)	28
④ Төсөл No. 4	
5 дахь удаагийн олон улсын байгальорчны тухай форум~Хил хязгааргүй байгаль~ (Далайн эргийн бүс нутаг)	30
IV Дараагийн координатын бүс	32
1 Дараагийн координатын бүсийн оролцох сонирхолтой бүсийн хэрэгжүүлэх ажил	32
2 Судалгааны үр дүн	32
V Байгаль орчны хүрээлэнгийн үйл ажиллагааны төлөвлөгөө	33

Япон Тояма Аймаг

(2011он 3 сар)

I Хэсэг бүс нутагийн байгаль орчны өнөөгийн байдал ба цаашдын арга хэмжээний тухай илтгэл

1 Тояма муж

Тояма мужийн байгаль орчны байдалд авч буй арга хэмжээний тухай

2010 оны 10-р сарын 11-нээс 30-ний хооронд Японы Айчи мужийн Нагоя хотод зохион байгуулагдсан НҮБ-ын амьд организмын биологийн төрөл зүйл 10-р гэрээ хэлэлцээрийн чуулга уулзалттай уялдуулан Тояма мужид амьд организмын олон талт байдлын чухалыг бодох "COP10 хамтарсан үйл ажиллагаа" болгон дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

1. Дэлхийн байгаль орчин ба ногоон организмын тухай дүрс бичлэгийн баяр Нагояд

Зохион байгуулагдсан өдөр: 10 сарын 9-нөөс 10-ны хооронд

Зохион байгуулагдсан газар: Айчи мужийн Нагоя хот

Тояма муж нь 1993 оноос Тоямад 2 жил тутамд Дэлхийн байгаль орчин ба амьд байгалийн тухай дүрс бичлэгийн баярын зохион байгуулалтыг дэмжиж ирсэн. Тус дүрс бичлэгийн баяр нь дэлхийд 3-т ордог байгаль орчин ба ногоон организмын тухай дүрс бичлэгийн баярын нэг бөгөөд өнгөрсөн оны 8 сард зохион байгуулагдсан 9 дэх удаагийн баярт 40 орны 347 бүтээл оролцож ойролцоогоор 14300 хүн шагнал хүртсэн. Мөн дэлгэцээр Токио болон Ёкохама гэх мэт Тоямагаас бусад газруудад гаргасан.

Энэ удаагийн COP10-т уялдуулан байгаль орчин баамьд байгалийн тухай дүрс бичлэгээр дамжуулан байгаль орчноо хайрлах хамгаалах үзэл бодол, ухамсарыг хүмүүст суулгах, хүний амьдралд байгаль орчин ямар чухал зүйл болохыг ойлгуулахын тулд шилдэг бүтээлүүдийг Нагояд дэлгэцээр гаргасан.

Дараагийн удаагийн 10-р дүрс бичлэгийн баярыг 2011 оны 8-р сард Тояма мужид зохион байгуулахаар төлөвлөж байна.

2. Япон тэнгисийн байгаль орчны олон талт байдлын форум

Зохион байгуулагдах өдөр: 10 сарын 16-ны өдөр

Зохион байгуулагдах газар: Тояма мужийн Тояма хот

NEAR байгаль орчны дэд хорооны хэсэг болох Япон тэнгисийн байгаль орчны хамтын ажиллагааны төв (NPEC) нь Япон, Хятад, Солонгос, Орос зэрэг орны Засгийн газарууд оролцсон, НҮБ-ын байгаль орчны төлөвлөгөө (UNEP) -г дэмжих Номхон далайн баруун хойд хэсгийн бүс нутагийн мөрийн хөтөлбөр (NOWPAP) -ийн бүс нутагийн оролцогч төв болж далайн хүрээлэн буй орныг хамгаалах арга хэмжээг авч буй ба Тояма муж нь NOWPAP болон NPEC-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллаж байна.

COP10-т уялдуулан Тояма муж нь UNEP болон NPEC-тэй хамтын ажиллагааны холбоо тогтоон, COP10-д оролцохоор Японд ирсэн хэсэг бүс нутагийн мэргэжилтнүүдийн багт хамтран оролцож далайн хүрээлэн буй орчин болон далайн олон талт байдлын талаар тунгаан бодох форумыг зохион байгуулсан.

Форумд UNEP-ээс биологийн төрөл зүйлийг тойрсон нөхцөл байдлыг нэгтгэсэн далайн амьд организмын биологийн төрөл зүйлтэй холбоотой илтгэлийн агуулга нь COP10-т түрүүлж тавигдсан. Тус илтгэлээс үзэхэд 2050 онд Номхон далайн баруун хойд бүс нутагт (Япон тэнгис, Шар тэнгис) -т агаараас замгархаг бодис буух нь ихсэж, усны ундарга багасаж, гадны төрөл зүйл ихсэж, төрөл зүйл нь мөхөх байдал ихсэх төлөвтэй байна. Мөн NPEC-ээс биологийн төрөл зүйлд анхаарал хандуулж далайн байгаль орчныг үнэлэх аргын судалгааны талаар танилцуулж байсан.

Мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэгт тус форумд оролцсон Номхон далайн өмнөд бүс нутагийн байгаль орчны төсөл ба Шар тэнгисийн өргөн хүрээг хамарсан экологийн төсөлийн мэргэжилтнээс бүс нутаг бүрт авч хэрэгжүүлж байгаа далайн эргийн байгаль орныг хамгаалах үйл ажиллагааны талаар танилцуулснаас гадна бүс нутагийн хүрээний асуудлыг шийдвэрлэхийн тулд бүс нутагийн талаарх мэдээлэл цуглуулж тус мэдээлэлийг дэлхийн хэмжээний шинэ хандлагад ач холбогдол болгох нь үр өгөөжтэй бөгөөд Тояма муж болон NOWPAP-ийн хамтын ажиллагаа нь олон улсын хэмжээнд хамтран хэрэгжүүлэх нь чухал юм гэсэн санал байсан.

Мөн тус форумын үр дүн ба Тояма мужийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай UNEP ээс зохион байгуулсан COP10 ын арга хэмжээнд дэлхий дахинд хандаж танилцуулагдаж байсан.

2 Хүкүи муж

Хүкүи мужийн байгаль орчны байдал болон цаашид авах арга хэмжээний тухай

ОХүкүи мужийн байгаль орчны талаарх үндсэн төлөвлөгөөний бодлого

Хүкүи муж нь 2008 оны 11 сар тус мужийн байгаль орчны арга хэмжээний чиглэл болох Хүкүи муж байгаль орчны үндсэн төлөвлөгөөг шинээр боловсруулсан. Уг төлөвлөгөөнд “Ард иргэдийн гараар хайрлагдаж хамгаалагддаг Хүкүигийн үзэсгэлэнт байгаль”-ийг зорилгоо болгож “Байгаль орчин”, “Амьдралын орчин”, “Байгаль орчноо бодож үйлдэл хийдэг хүмүүсийг бүтээх” гэсэн 3 зүйлд үндэслэн улс даяараа системтэй төлөвлөгөөг авч хэрэгжүүлэх болоод байна.

Эдгээрийг бодитоор хэрэгжүүлэхийн тулд ард иргэдийн оролцоо юу юунаас чухал юм. Төсөлд иргэдийг байгаль орчны үйл ажиллагаанд өргөнөөр оролцуулах нь маш чухал асуудал болгож, тодорхой арга хэмжээг 10 төсөл болгон багцалсан. Улмаар “Байгаль орчин Хүкүи мужийн иргэдийн хурал”-ыг зохион байгуулж байгаль орчинтой холбоотой салбараас гадна эдийн засаг, хөдөө аж ахуй зэрэг салбаруудын арга ухаан болон үйл ажиллагааг нэгтгэж иргэдийн үйл ажиллагаагаар шинэ дэлхийг бүтээх, дэлхийн байгаль орчны асуудалыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, түүнийг хөгжүүлэхийн төлөө төсөлдөө оруулж байгаль орчны цогц төсөлийг хэрэгжүүлэхийг зорьж байна.

« Байгаль орчин »

Байгаль орчныг хадгалах хамгаалах, биологийн төрөл зүйлийн хамгаалалт, ногоон ургамалыг үржүүлэх, байгалийн гоо үзэсгэлэн болон түүх дурсгалын орныг бүтээх гэх мэт

ОТодорхой арга хэмжээ

- Байгалийг сэргээх Хүкүи үйл ажиллагааны төсөл
- Ой мод нугыг хамгаалах үйл ажиллагааг дэмжих төсөл

« Амьдралын орчин »

Байгалын баялаг болон энэргийн хэрэглээг хязгаарлах болон эргэлттэй хэрэглээ, хог хаягдлыг багасгах, усны ундаргын орчныг цэвэр байлгах, агаар, ус, шороо зэргийн байгаль орчны бүтцийн хүчин зүйлийг сайтар хамгаалах

ОТодорхой арга хэмжээ

- Байгаль орчин Хүкүи CO₂ –ыг багасгахад хувь нэмэр оруулах төсөл
- Ирээдүйд эрчим хүчийг хэмнэх машиныг нэвтрүүлэхийг дэмжих төсөл
- Стоп төсөл
- Орчноо нандигнах нийгмийг бий болгох төсөл
- Хүкүигийн цэвэр ус төсөл

« Байгаль орчноо нандигнан хайрлах үзэл санааг хүмүүст ухамсарлуулах төсөл »

Байгаль орчны талаарх системтэй сургалтыг дэмжих, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг дэмжих, байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуй, усны үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчинтой холбоотой аж үйлдвэрийг хөгжүүлэх, ерөнхий болон үндсэн арга хэмжээг дэмжих зэрэг

ОТодорхой арга хэмжээ

- Хүкүи хэлбэрийн байгаль орчны талаарх боловсрол, сургалтыг дэмжих төсөл
- Дэлхий нийтээрээ хамтарсан хүүхдүүдийн байгаль орчны төсөл
- Цэвэр хот байгуулах төсөл

3 Kyngsangnamdo

Kyngsangnamdogийн байгаль орчин ба нийгмийн хамгаалалын бодлого

1. Байгаль орчны ерөнхий байдал

1) Байгаль орчны бодлогыг дэмжих чиглэл

2008 онд Kyngsangnamdод зохион байгуудагдсан Рамсар уулзалт нь амжилттай өндөрлөсөн бөгөөд “Кёнгнамийн байгаль орчин” –ны имижийг бүрдүүлэхийн зэрэгцээ ши нэ улс төрийн алсын хараатай бодлого “Бага хэмжээний нүүрс төрөгч ба ногоон ургамалын өсөлт (Low carbon green growth)”-д тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийн тулд “Ард иргэдийнхээ амьдралын түвшинг дээшлүүлэх, ногоон ургамалыг тариж ургуулах үндэс суурийг тавих”-ыг байгаль орчноо хамгаалах арга хэмжээний зорилго болгосон.

Энэхүү зорилтдоо хүрэхийн тулд ①Тасралтгүй үргэлжлэх хөгжил цэцэглэлтийн төлөө байгаль орчны бодлогыг дэмжих, ②Цаг уурын өөрчлөлттэй холбогдуулан азотын хийг багасгах бодлогыг дэмжих, ③Байгалийн баялагаа хадгалахад Кёнгнамийн байгаль орчны брэндийг бий болгох, ④Цэвэр усаа хадгалах ба хамгаалах болон хянах, ⑤Цэвэр усыг тогтмол нийлүүлэх, ⑥Ойн баялагаа хадгалах болон ногоон байгууламжийн сүлжээг бий болгох, ⑦Ойн экологийг хадгалах болон ногоон бүсийн амралтын газрыг өргөтгөх гэсэн 7 том бодлогыг зорилт болгож зорилгодоо хүрэхийн тулд нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2) “Кёнгнамийн байгаль орчны тунхаглал” нарийвчилсан төлөвлөгөө зохиох

Рамсар уулзалтыг үндэслэн “Бага хэмжээний нүүрс төрөгч ба ногоон ургамалын өсөлт”-д тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийн тулд 2008 оны 10-р сард “Кёнгнамийн байгаль орчны тунхаглал”-ыг зарлаж, уг тунхаглалд агуулагдах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд нарийвчилсан төлөвлөгөө боловсруулсан. Тус төлөвлөгөөнд 2020 он хүртэлх нийт үйл ажиллагааны зардалд 6 млрд 6,0 триллион вон-ны төсөвлөж, ногоон бүсийг байгуулах үндэс суурийг тавьх салбарын 17-н асуудал, ногоон энерги шинээр хөгжих хөдөлгөгч хүч болох үйлдвэрлэлийг хөгжүүлэх салбарын 10 асуудал, пост рамсар бодлогын дэвшилээр Кёнгнамийн байгаль орчны брэндийг бий болгох салбарын 13 асуудалыг тус тус дэмжих болсон.

3) Ногоон ургамалыг тарих ургуулах тухай форумыг зохион байгуулах

Ногоон ургамалыг тарих ургуулах тухай форум нь ногоон ургамалыг тарих ургуулах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд санаагаа нэгтгэж, иргэн бүр нэг сэтгэлээр хамтран ажиллахын төлөө байгаль, эдийн засаг, нийгэмийн бүхий л салбартай хамтран хамтын холбоо тогтоохын зэрэгцээ цаг уурын өөрчлөлттэй холбоотой олон улсын байгаль орчны бодлогын хурдацтай өөрчлөлтөд хандаж зөв зүйтэй үнэлж, хурдан шуурхай арга хэмжээ авахын тулд байгуулагдсан. 2009 оны 2-р сарын 9-нд Акирахара чуулга уулзалтын төвд зохион байгуулалттай уулзалт болж, төлөвлөөн ёсоор 1-р семинар мөн болсон. Ногоон ургамалыг тарих ургуулах тухай форум нь үйлдвэрлэл, сургалт, дадлага, хяналт гэсэн байдлаар идэвхтэй оролцоо ба хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг гол болгож дэмжихийн зэрэгцээ post-2012-ийн бэлтгэлийн эрчимтэй хийж, засгийн газарын алсын хараатай бодлогыг хамсруулан харилцан хөгжих чиг хандлагыг барихыг зорилгоо болгосон. Өнөөгийн байдлаар 2-р семинарыг зохион байгуулаад байгаа бөгөөд цаг уурын өөрчлөлтийн байдлын тухай олон улсын симпозиум зэргийг зохион байгуулж, Kyngsangnamdogийн ногоон ургамалыг тариж ургуулах зөвлөлийг байгуулж улмаар менежментийн нэгдсэн

төлөвлөгөөг боловсруулж байна.

2. Цаг уурын байдлыг зүй зохистойгоор хамгаалах

Gyeongnam-ын агаарын бохирдлын хэмжээ нь бага хэмжээний хүхэрлэг түлш болон байгалийн шингэн хий(LNG) зэргийн цэвэр түлшийг нийлүүлэгч бүс нутагийн тархалт, агаарыг бохирдуулагч бодисыг зайлуулагч үйл ажиллагааныханд хандсан удирдлагын хяналтыг сайжруулах, авто тээврийн хэрэгсэлээс гарч буй хаягдал хийг багасгах арга хэмжээг эрчимжүүлэх, машинаа түр зогсоохдоо унтраах болон байгалийн хийг ашигласан авто машиныг олшруулах, авто машины сул зогсолтыг багасгах болон байгалын хийгээр(CNG) явдаг машиныг олшруулах зэргээр нүүрс хүчил хүхэр, угаарын хийн концентраци нь жил ирэх тусам сайжирч байна.

Гэвч саяхнаас авто машины хэрэглээ нь маш хурдацтай өссөнөөс авто машины утаанаас ялгарч буй азотын хоёрдогч эсэл, бичил тоос, озоны концентраци нь бага зэрэг нэмэгдсэний улмаас хотын агаарыг бохирдуулагч гол хүчин зүйл болох дизелийн түлш ашигладаг хот доторх автобус зэрэг том оврын авто машиныг утаа огт гардаггүй байгалийн хийг ашигласан машинаар солих үйл ажиллагааг дэмжиж байна. Мөн 2008 оны 1-р сарын 1-нээс агаарын орчныг хамгаалах шаардлагатай бүс нутагаар тогтоогдсон Gimhae-si, Hadong дулааны цахилгаан станц болон хүн ам 500000-аас дээш хот болох Changwon-д авто машины тал дээр нэгдмэл тогтолцоог нэвтрүүлж судалгаа хийж байна.

1) Азотын хийг багасгах арга хэмжээг дэмжих

(1) Агаарын өөрчлөлтийн эсрэг авах нэгдмэл арга хэмжээг боловсруулах

Цаг агаарын өөрчлөлтөөс шалтгаалж далайн түвшин нэмэгдэх зэрэг сөрөг нөлөө ба аюул дэлхийд нүүрлэж буй бөгөөд азотын хийн хаягдалын дүрэм нь шинэ худалдааны бэрхшээл болж байгаагийн дотор Gyeongnam-д “Нүүрс хүчлийн хийг багасгах, ногоон ургамалыг өсгөх” арга хэмжээг авч, цаг агаарын өөрчлөлтийн эсрэг идэвхтэй арга хэмжээ авахын тулд “Gyeongnam-д цаг уурын өөрчлөлтөд хандсан цогц төлөвлөгөө”-г боловсруулж төлөвлөгөөг дэмжиж байна.

(2) Green Start Network-ийн менежмент

Gyeongnam-д Green Start Network нь нүүрс хүчлийн хийг багасгаж ногоон орчныг бий болгох, улсын хэмжээгээр азотын хийг багасгах зорилгодоо хүрэхийн тулд азотын хийн хаягдлын 43 хувийг эзэлдэг гэр ахуйн ба зам харилцааны, худалдааны зэрэг үйлдвэрлэлийн буссалбарын азотын хийг багасгахад чиглэсэн нийт иргэдийг оролцуулах хөдөлгөөнийг өргөжүүлэхийг зорьж 2008 оны 12-р сард зохион байгуулсан. Өнгөрсөн жилийн 2 сард төсөл ажлыг зохион байгуулж хотын иргэдийн оролцоо болон хэрэгжүүлэлтийг дэмжих ногоон амьдралыг бий уур амьсгалыг бүрдүүлж байна.

(3) Азотын хийг багасгах нүүрч хүчлийн поинтын системийн менежмент

Азотын хийг багасгах үйл ажиллагаанд оролцох уур амьсгалыг бий болгохоор амьдралд нүүрс төрөгчийн хэрэглээг багасгах, цаг агаарын өөрчлөлтөд хандсан иргэдийн ухамсарыг өөрчлөхийн тулд хувийн орон сууц, худалдааны байгууллагыг объектоо болгож нүүрс хүчлийн поинтын системийг удирдаж байна. Нүүрс хүчлийн поинтын систем нь оролцогчид идэвхтэйгээр цахилгаан хэрэгсэл, усны хоолой, газ зэргийн энергийг хэмнэж, ингэснээр хэмнэсэн нүүрс төрөгчийн хийн хэмжээг поинт болгох, урамшуулах азотын хийг бууруулах төсөл юм.

(4) Олон нийтийн байгууллагаас хэрэгжүүлж буй нүүрс төрөгчийн хаягдлын би знес моделин үйл ажиллагаа

(2020 он) Улсын хэмжээгээр азотын хийг бууруулах зорилгодоо үр дүнтэй хүрэх, суурьтай тогтолцоог нэвтрүүлэх, менежментийн сургалт болон холбогдох дэд бүтцийн бэлтгэлийг хангахын тулд 2010 оноос 2012 он хүртэл олон нийтийн байгууллагаас нүүрс төрөгчийн хаягдлын бизнес моделин үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Уг үйл ажиллагаа нь 2007-2008 оны хооронд нүүрс хүчлийн хийн хэмжээг 3%-иар бууруулахыг зорилго болгож хэт илүү байх болон бууруулах хэмжээг хугацаагаар хувааж интернэтээр худалдах юм.

3. Хэт чийгтэй орчинд авах арга хэмжээг дэмжих

2008 оны 10-р сарын 28-наас 11-р сарын 4-ний өдөр хүртэл Gyeongnam-ийн Аки харад 140-өөд орны төр засгийн төлөөлөгчид болон намагшсан бүс нутагийн мэргэжилтэн, төрийн бус байгууллагын 2300-аад хүмүүсийн оролцсон түүхэнд тэмдэгдэх өргөн хэмжээний хэт чийгшилтэй бүс нутагийн 10-р чуулга уулзалт амжилттай болж өндөрлөлөө. Уг чуулга уулзалтад 1) Манай улсын авч хэрэгжүүлж буй ногоон ургамалын тариж ургуулах ажлыг дэмжих стратегийг бусдад мэдүүлэх зэрэг байгаль орчны түвшинг дэлхий нийтэд мэдүүлэх явдалар олон улс дахь нэр хүндээ өсгөх боломж олгогдсон явдал болон, 2) Иргэдийн экологийн үзэмж, чийг намагшилтай газар, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон сонирхолыг өсгөх, чуулга уулзалтын дараа Ramsar хурлаар чийгшилтэй газарын талаарх мэдлэгийн нэмэгдүүлэхэд хувь нэмэр болсон хэмээн үнэлсэн үнэлгээ нь 80 хувьд хүрсэн ба чийгтэй газарын үнэлгээг дахин ойлгох завшаан болсон нь их амжилт гэж хэлж болно. Мөн Gyeongnam-до нь рамсар уулзалтыг зохион байгуулснаас Солонгосын байгаль орчны төв хэсэг болон хөгжих боломжийг атгаж чадсан.

Ингэснээр Gyeongnam нь рамсар уулзалтыг нэг удаагийн олон улсын нээлттэй өдөрлөг төдийгөөр дуусгавар болгох бус байгаль орчны төв хот Gyeongnam болж хөгжихийн төлөө тодорхой системтэй арга хэмжээ авах бэлтгэлээ хангах, Gyeongnam-ийн байгаль орчин гэсэн брэндийг бий болгох, ① хөгжил ба хамгаалалтыг хавсарган чийгшилтэй нутагийг хамгаалах хянах болон байгаль орчны арга хэмжээг дэмжихэд гол үүрэгтэй явдал, ② рамсар байгаль орчны байгууллага болон Зүүн Азийн рамсар бүс нутагийн төвийг байгуулж Ази дахь чийгтэй газарыг хариуцах гол үүргийг гүйцэтгэх, ингэснээр том хэмжээний олон улсын байгаль орчны хуралд оролцоноор Gyeongnam-ын байгаль орчны байр суурийг өсгөх болон Уро намаг зэрэг мужийн гол экологийн баялагийг ашиглан экологийн аялал жуулчлалыг идэвхжүүлэхийг дэмжих, бүс нутагийн эдийн засгийн идэвхжүүлэлтийг хэмжихийн тулд рамсар төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж “Gyeongnam-ийн байгаль орчин”-ий байр сууриа өндөрсгөж байна.

Үүний нэг төлөөлөх арга хэмжээ бол экологийн (чийгтэй бүс) нөхөн сэргээлтээр биологийн төрөл зүйлийн хамгаалалт, чийгтэй газарыг хадгалах бодлогыг өндөржүүлэхийг зорилго болгож “Уро намагийн экологийн (чийгтэй бүс) нөхөн сэргээлтээрх биологийн төрөл зүйлийн хамгаалалт”, олон улсын хэмжээгээр устах магадлалтай шувууны төрөл болох ибисыг тогтвортой өсгөх, нөхөн сэргээхийг зорьж “үржүүлэх үйл ажиллагааг амжилттай дэмжих” зэрэг рамсар байгаль орчны арга хэмжээг дэмжин ажиллаж байна.

4. Nakdong-gang усны чанарыг сайжруулах арга хэмжээ

Nakdong-gang голын урсгалын бүсийн голын бохирдлын эхийг үүсвэрийг сайтар

хянахын тулд Gyeongnam-ийн хяналтад нийт 94 газарт усны чанарыг хянах төхөөрөмж байг уулж, судалгааны зүйлээр тодорхой хугацаанд усны чанарыг шинжлэх ажиллагаа явагдаж байна. Мөн Nakdong-gang голын ай савын гол болох Gwangnyeongsheon-д усны чанарыг хянах төхөөрөмж байршуулж өдөр бүр pH、COD、DO、цахилгаан дамжуулах хэмжээ, усны дулаан зэргийг хэмжиж байна. Улмаар байгалийн агаарын мониторингийн менежмент зэргийн байнгын мониторингийн ажиллагааг хийж, бохирдлын эх үүсвэрийг хянах арга хэмжээг маш нарийн авч Nakdong-gang голын усны чанарыг хянахыг хичээн ажиллаж байна.

1999 онд Засгийн газартай хамтран “Nakdong-gang усны хяналтын нэгдмэл арга хэмжээ” –г авч баримтлах, түүнийг хуулийн хүрээнд хэрэгжүүлэхийн тулд 2002 оны 1 сард “Nakdong-gang усны хяналт болон иргэдийн дэмжлэгтэй холбогдсон хууль”-г баталсан. Уг хуулинд үндэслэн 2010 он гэхэд Nakdong-gang усны чанарыг 2-р зэрэгт (BOD3.0mg/l) хүргэхийн тулд “Nakdong-gang усны хэлбэрийн Gyeongnam бохирдлын нэгдсэн хэмжээн ий хяналтын үндсэн төлөвлөгөө”-г боловсруулж бохирдлын эх үүсвэрийг шинжлэх ухааны болон системтэйгээр хянах байдлаар усны чанарыг сайжруулахаар ажиллаж байна.

Мөн үйлдвэржилт, хотжилтоос болж бохирдож байгаа голыг өмнөх байдалд нь буцаан сэргээх байдлаар усны чанарыг сайжруулах, экологийн цэвэр байдлыг хадгалсан голыг бүтээхийн тулд экологийн голыг сэргээх үйл ажиллагааг дэмжиж байна.

Улмаар Nakdong-gang голын усны чанарыг сайжруулахын тулд бохир усыг ялгах төхөөрөмжийг байршуулж үйлдвэрлэлийн газар болон хөдөө аж ахуйн газарлуу урсаж буй усыг тодорхой хэмжээгээр шүүж байна. Мөн хотжилтоос үүссэн бохир усыг шийдвэрлэх арга хэмжээг идэвхтэй авч хүн ам ихээр суурьшсан бүс нутагт хотын төв хэсгийг гол болгож бохир усны төрөөрөмжийг байрлуулж тоног төхөөрөмжийг сайжруулах төлөвлөгөөтэй байна.

5. Nakdong-gang усны бохирдлын нийт хэмжээг хянах

Усны бохирдлын нийт хэмжээг хянах тогтолцоо нь голын хэсгийн хооронд тодорхой чанарыг тогтоож зорилт тавьсан усны чанарт хүрэх, үргэлжлүүлэхийн тулд бохирдуулагч юмсын хэмжээг хэмжиж, тус бүсийн ай савд хаягдаж буй бохир бодисын хаягдлын хэмжээг зөвшөөрөгдсөн хэмжээнээс доош байхаар хянах тогтолцоо юм. Энэ нь орон нутагийн засаг захиргаанд хаягдлын хэмжээг багасгасан хэрээр, тухайн бүс нутагийн хөгжил өсөх болохоор усны чанарын аюулгүй байдлыг хангахын төлөөх хичээн зүтгэл нь тухайн бүс нутагийн засаг захиргааны хөгжлийн түлхэц болох “байгаль ба хөгжил”-ийг хамтад нь харгалзан үзэх тогтолцоо юм.

Nakdong-gang усны бохирдлын нийт хэмжээний тогтолцоо нь 1999 оны 12 сард “Nakdong-gang усны хяналтын нэгдмэл арга хэмжээ” –ээр нийт хэмжээний хяналтын тогтолцооны хэрэгжүүлэлтийг авах болж 2002 оны 1 сард “Nakdong-gang усны хяналт болон иргэдийн дэмжлэгтэй холбоотой хууль”-аар хуулийн хүрээнд хэрэгжүүлэх болж, “Nakdong-gang усны бохирдлын хэмжээг хянах үндсэн чиглэл” –ээр менежмент, хяналт хийгдэж үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

1-р шат нь 2004 оноос 2010 он хүртэл, 2-р шат нь 2011 оноос 2015 он хүртэл бөгөөд тухайн хүрээний бүс нутагийн засаг захиргаа нь шат тус бүрт байгаль орчны хэсгийг бүрдүүлж, зарласан бүс нутагийн хамгаалалтын бүсийн зорилт болгосон усны чанарт хүрэхийн тулд үндсэн төлөвлөгөө боловсруулж байгаль орчны хэсгээс батламж авах

хэрэгтэй болно. Түүнчлэн нэг бүс нутагийн засаг захиргаа нь тухайн нэг нэгжийн сав г азараас бусад зөвшөөрөгдөж болох хэмжээнээс хэтэрсэн хүрээнд хөгжлийн үйл ажиллагаа, бууруулах арга хэрэгслийн төхөөрөмж зэргийг тодорхой байдлаар хэрэгжүүлэх төлөв лөгөөг боловсруулж өргөн хүрээний бүс нутагийн засаг захиргааны баталгаагаар жил бүр үр дүнгийн үнэлгээг хийж байна.

6. Ахуйн хаягдалын хэмжээг багасгах ба дахин боловсруулах

Гyeongnam-ийн ахуйн хэрэглээний хаягдлын үүсэх хэмжээ (2008 оны 12 сарын сүүлчээр) нь 2810 тн байсан бөгөөд үүний дотор дахин боловсруулах хаягдал нь түүхий хогийг оруулаад 1427 тн (51%) байсан.

Хог хаягдлын асуудлыг шийдвэрлэхийн тулд хаягдлыг үүсгэхийг багасгаж, яалт ч үгүй үүссэн хаягдлыг их хэмжээгээр дахин боловсруулах нь зүйтэй юм. Үүний тулд Gyeongnam-д хаягдлын бага хэмжээтэй болгох аргатай хамтатган баярлагийг эргэлтэнд оруулах замаар дахин боловсруулах тогтолцоог хэрэгжүүлэхэд хүчээ дайчлан ажиллаж байна.

Үүний нэг төлөөлөх арга бол хаягдал үүсэх үе шатын бууруулж, дахин боловсруулалтыг хийж буй үйлдвэрлэгчид дахин боловсруулах хариуцлагыг оногдуулж, дахин боловсруулах боломжтой зүйлийг тогтвортой нийлүүлэхийн тулд ялгаж хуваах арга хэмжээ авч, бүс нутагийн нөхцөлд тохирсон байгууламжийг өргөсгөж, дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг хэрэглэхийг уриалах, нэг удаагийн хэрэглээний зориулалттай зүйлийг хязгаарлах, хүнсний бүтээгдэхүүний хаягдлын хэмжээг бууруулахыг уриалах зэргээр хаягдал болон дахин боловсруулах арга хэмжээгээр дамжуулж “үргэлжлүүлэн хэрэглэх боломжтой баялагийг эргэлтэнд оруулах нийгэм” г бүрдүүлье хэмээн хичээж байна.

Улмаар Gyeongnam-д азотын хийг багасгах болон бага нүүрс хүчлийн хий ба ногоон ургамалыг өсгөхийн тулд нурам болсон талбайг эрүүл болгох, дахин ашиглах, хогийн цэгээс ялгарч буй метаний хийг зогсоох, ашиглах, хүнсний бүтээгдэхүүний хаягдлын энергийн байгууламжийг барих зэргээр хаягдал зүйлсээс гарах энергийг ашиглах үйл ажиллагааг дэмжиж байна.

4 Сахалин муж

Сахалин мужийн байгаль орчны өнөөгийн байдлыг тухай

Сахалин мужийн байгаль орчныг хамгаалах асуудал нь ард иргэдийн дунд шийдвэрлэвэл зохих нэн тэргүүний асуудал болоод байна. 2009 оны Сахалин мужийн байгаль орчны байдлын үзүүлэлтээс харахад Сахалин мужийн байгаль орчинд том өөрчлөлт гараагүй байгаа ч тусгайлан авч үзвэл байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг дэмжихтэй холбоогүйгээр маш чухал асуудал байсаар байна.

<Агаар мандал>

2008 он болон 2009 онд Сахарин мужийн агаарын бохирдлын хэмжилтийг 5 хот болон (Novoaleksandrovsk) дүүрэгт хийсэн .

Агаарын бохирдол маш ихтэй хот нь Южно-Сахалинск байсан. ЗХУ-д 20 оноос хойш тус хот нь агаарын бохирдол ихтэй хотын нэг гэгдэх болсон. Агаарын өтгөрөл ихтэй, өтгөн утааны хайрдагад HCHO, C₂O_H₁₂ зэрэг бодис агуулагддаг байна. Хамгийн их агаар бохирдолтой хот нь Оха хот юм.

Южно-Сахалинск хотын нэгдүгээр цахилгаан станцын түлшийг газар солисноос агаар нилээд сайжирсан. Хөрөнгө оруулалтын төсөл нь цахилгаан эрчин хүчний асуудалд чиглэсэн бөгөөд станцийн түлшийг нүүрс байсныг байгалийн хий болгон өөрчиллэхээр төлөвлөсөн.

Орон нутгийн бойлорыг газар солисноор бүсийн хот, тосгоны байгаль орчны байдал сайжирна.

<Усан мандал>

Усан мандалын усны чанарын хэмжилт нь 29 голын 33 хэсэгийг хэмжилтийн хэсэг болгож 42 газарт усны тэмдэг тавьсан. Хэмжилтээр нийт голын усны чанар муу гарсан байна. Нефти газрын тосгоос ялгарсан бодис, аммоин, нитроген, HNO₂, төмөрлөг эд зүйлсээс хамаарч ихээхэн бохирдсон байна.

Орон сууц болон олон нийтийн байгууллагыг оролцуулан аж ахуйн нэгж, байгууллага зэргийн бохир ус голруу урсан орж байна. Сахарин мужийн гол тулгамдсан асуудал нь хот тосгонд бохир усыг зайлуулах байгууламж байдаггүй. Түүнчлэн одоогийн хэрэглэгдэж байгаа бохир усны байгууламжийнх нь хүчин чадал муу болсны улмаас голруу урсгаж буй бохир усны цэвэрлэлт нь хангалттай бус байна. Иймээс усны магдалын чанар маш муу болоход ихээхэн нөлөөлж байна.

Иргэдэд чанарын шаардлага хангасан ундны усыг нийлүүлэхийн тулд мужийн төр засаг нь “Сахарин мужийн иргэдийн ундны усыг хамгаалах хадгалах” гнмнг төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Түүнчлэн “цэвэр ус” гэсэн төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж 2010 оноос эхэлсэн. Уг төслөөр усны төв хоолойн усыг хэрэглэх хүмүүс ихсэж, усны хоолойн усны чанарыг сайжруулахаас гадна крантны усны хэрэглээний хэмжээг хянахын тулд ус хэмжигчийг байрлуулаад байна.

<Далайн ус>

Далайн усны орчны хэмжилтэнд далайн ус болон далайн ёроолд бохирдлын хэмжээ ихээр гараагүй. Далайн усны чанар болон далайн ёроолын байдал нь хэдэн жилийн өмнөхтэй харьцуулахад адилхан байсан. Түүнчлэн мониторингийн бүс нутаг болох Сахалины

Александровск боомт, Стародовск боомт, Корсаков боомт, Пригородны боомтын эргэн тойронд үйл ажиллагаа явуулж буй ау ахуйн нэгж нь далайн усны чанарт муу нөлөө үзүүлж байна гэсэн зүйл батлагдаагүй болно.

<Хаягдал>

Сахалин мужийн үйлдвэрлэл, хэрэглээтэй холбогдон үүсч буй хог хаягдлыг цэгцлэх, дахин боловсруулах асуудал нь байгаль орны байдлыг сайжруулах, тогтвортой байлгах, цаашлаап баялагийг үр өгөөжтэй ашиглахын тулд маш ёухал зүйлийн нэг болох юм.

Үйлдвэрлэл, хэрэглээтэй дагалдан хогхаягдлын асуудал үүсч түүнийг хариуцах, дахин боловсруулах, хоргүй болгох, булах зэршээр байгаль орчинд хор нөлөөгүй болгохын тулд Сахалин мужийн Засгийн газарын шийдвэрээр 2008 оны 9 сарын 22 нд №293 “Сахалин мужийн үйлдвэрлэл, хэрэглээтэй холбогдон үүссэн хог хаягдал (2009—2015) ” гэсэн урт хугацааны төлөвлөгөөт ажлыг баталсан.

2009 онд Южно-Сахалинск хотын төлөө том оврийн хог хаягдал зориулсан булах цэгийг байгуулах төсөлийг эхлүүлэхээр болж, 2010 оноос байгууламжийш эхлүүлсэн. Уг төслийн хүрээнд Южно-Сахалинск хотоос бусад хот тосгонд ч том оврийн хог хаягдал зориулсан булах цэгийг байгуулагдах болсон. Түүнчлэн төсөлд хоргүйжүүлэх ба пахин боловсруулах зорилгоор ашиглах боломжгүй пестицидыг мужаас гадагш гаргахыг төлөвлөөд байна.

II Байгаль орчны эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны байдал

1 9 дэх удаагийн байгаль орчны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах

(1) Өдөр: 2009 оны 7 сарын 8

(2) Оролцогч: 5 орны 15 бүс

Япон (4) Нийгата, Тояма, Ишигава, Тоттори муж

Хятад (3) Лианонинг, Хэйлунцзян, Хунань

Монгол (1) Өвөрхангай аймаг

Солонгос (5) Канвондо, Чхунчхон, Кенсан, Чхунчхон, Ульсан

Орос (2) Далайн эргийн бүс, Хабаровск

(3) Хурлын үр дүн

а Зарим бүсийн байгаль орчны байдал болон тулгамдсан асуудал

5 бүс (Нийгата, Ишигава, Тоттори муж, Чхунчхон-Намдо, Хабаровск) -ээсбайгаль орчны байдал болон цаашдын асуудлыг талаарх илтгэл тавьгдсан.

б 2009 оны тусгай хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

5 төслийн хэрэгжилтийн тухай танилцуулагдаж доорх 4-ийг хэрэгжүүлэхээр болсон.

「4 дэх удаагийн олон улсын эдийн засгийн форум (Хабаровскийн бүсийн төсөл) 」-ийн тухайд дэлхийн эдийн засгийн хямрал нүүрлэж, эдийн засгийн асуудал болон хямралыг даван туулах бодлогыг хэлэлцэх форум болгохын тулд байгаль орчны талаарх асуудлыг хэлэлцэхгүй болохыг мэдэгдсэн.

No.	Төслийн нэр	Төслийн бүс
1	Шар элсийг хянах өргөн хүрээний мониторингийн системийг бий болгох	Тояма муж
2	Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчны хөтөлбөр	Лианонинг, Тояма муж
3	Япон тэнгис, Шар тэнгисийн эргийн хаягдал зүйлст хийсэн судалгаа	Тояма муж
4	4 дэх удаагийн олон улсын байгаль орчны форум 「Хил хязгаараар хязгаарлагдахгүй байгаль」	Далайн эргийн бүс

в 2010 оны тусгай хөтөлбөрийн байдалын талаар

2010оны тусгай хөтөлбөр болгож дараах 4 төслийг санал болгож, түүний ерөнхий агуулгыг танилцуулж оролцогчдын оролцоог шаардсан.

No.	Төслийн нэр	Бүс
1	5 дэх удаагийн олон улсын байгаль орчны форум 「Хил хязгаараар хязгаарлагдахгүй байгаль」	Далайн эргийн бүс
2	Шар элсийг хянах өргөн хүрээний мониторингийн системийг бий болгох	Тояма муж
3	Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчны хөтөлбөр	Тояма муж
4	Япон тэнгис, Шар тэнгисийн эргийн хаягдал зүйлст хийсэн судалгаа	Тояма муж

г. Байгаль орчны эрдэм шинжилгээний зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар

Байгаль орчны эрдэм шинжилгээний зөвлөлийн цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар хяналт хийгдсэн.

д. Дараагийн координатын бүс (алба) -ийг сонгох

Дараагийн координатын бүс болгож үргэлжлүүлэн Тояма мужийг сонгосон. (2 жилийн хугацаагаар сунгасан)

※1999 оны 7 сараас 6 улирал дараалан явуулж байна

2 Тусгай хөтөлбөртэй холбогдох судалгааны хэрэгжилт

- (1) 2010 оны тусгай хөтөлбөрт оролцохыг сонирхогчдыг судлах судалгаа
(2009 оны 10 сар)
- (2) 2010 оны тусгай хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлын судалгааны хэрэгжилт
(2010 оны 5 сар)
- (3) 2011 оны тусгай хөтөлбөрийн төслийн хэрэгжилт
(2010 оны 5 сар)
- (4) 2011 оны тусгай хөтөлбөрийн төсөлд оролцох хүсэлтэй судалгааны хэрэгжилт
(2011оны 1 сар)

III Тусгай хөтөлбөр

1 2010 оны тусгай хөтөлбөр

(1) Санал болгох төсөл

Но.	Төслийн нэр	Санал тавих бүс
1	Олон улсын байгаль орчны 5 дахь удаагийн форум 「Хил хязгаар байргүй байгаль орчин」	Далайн эргийн бүс нутаг
2	Шар элстэй холбоотойгоор өргөн хэмжээгээр мониторингийн тогтолцоог бий болгох	Тояма муж
3	Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчны хөтөлбөр	Тояма муж
4	Япон тэнгис, шар тэнгисийн эрэг орчимд шидэгдсэн далайн хаягдлын худалгаа	Тояма муж

(2) Зарим нэг бүсийн засаг захиргааны оролцоо (◎ : санал болгох засаг захиргаа

○ : оролцогч)

Төсөл No.		1	2	3	4
Засаг захиргаа					
Япо н	Аомори муж	—	—	—	○
	Ямагата муж	—	○	—	○
	Нийгата муж	—	—	—	—
	Тояма муж	—	◎	◎	◎
	Ишигава муж	—	—	—	○
	Хүкүимуж	—	—	—	—
	Киото	—	—	—	○
	Хёгомуж	—	—	—	○
	Тоттори муж	—	○	—	○
	Шиманэ муж	—	—	—	—
Хята д	Liao Ning	—	○(※)	○	—
	Heilongjiang	—	—	○	—
Сол онго с	Kou Hara	—	○	○	○
	Chungcheongnam-do	—	○	○	—
	Gyeongnam	—	○	—	—
Оро с	Амур мөрөн	—	—	—	—
	Буриадын бүнд найрамдах улс	—	—	—	—
	Иркутск	—	—	—	—
	Хабаровск	—	○	—	○
	Далайн эргийн бүс нутаг	◎	○	○	—
	Саха бүгд найрамдах улс	—	—	—	—
	Сахарин	—	—	—	—
	Забайкарие бүс	—	—	—	—
	Тосмк муж	—	—	—	—

Мон гол	Төв аймаг	—	—	○	—
	Сэлэнгэ аймаг	—	—	—	—
	өвөрхангайаймаг	—	—	○	—
Оролцох бүс нутагийн тоо		—	4 орны 9 бүс	5 орны 8 бүс	3 орны 9 бүс

(※) Лионинг нь Тояма мужтай хамтарсан судалгааг хийж байгаа

(3) Төслийг хэрэгжүүлэх нөхцөл байдал

① Төсөл No. 1 「5 дахь удаагийн олон улсын байгальорчны форум-хил хязгаараар зааглагдахгүй байгаль」 (Далайн эргийн бүс)

1 Хэрэгжилтийн байдал

